Газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгаа хийлгэх	<b>1 500.0</b>	“Эхлэх цэг хангай” ХХК-иар гүйцэтгүүлсэн.
Эко “00” суулгах	<b>3 465.0</b>	“Жондоо гарден” ХХК-иар гүйцэтгүүлсэн.

### СИ БИ ЗИ ХХК АЖИЛЧДЫН ХУВЦАСНЫ ОЛГОЛТ

№	Овог нэр	Ажлын байр	Ажлын хувцас	Хантааз	Толгой хамгаалах хэрэгсэл	Гутал размер	Гарын үсэг
1	Баярбат	Уулын дарга, оперотор	Өмд, цамц	1 ширхэг	1 ширхэг	40	<i>Баярбат</i>
2	Бат-Эрдэнэ	Харуул	Өмд, цамц	1 ширхэг	1 ширхэг	41	<i>Бат-Эрдэнэ</i>
3	Мөнхтулга	Чулуу ялгагч	Өмд, цамц	1 ширхэг	1 ширхэг	40	<i>Мөнхтулга</i>
4	Лутбаяр	Чулуу ялгагч	Өмд, цамц	1 ширхэг	1 ширхэг	40	<i>Лутбаяр</i>
5	Гансүх	Гагнуурчин, засварчин	Өмд, цамц	1 ширхэг	1 ширхэг	41	<i>Гансүх</i>

Жагсаалт гаргасан: захирагч *В.Мөнхтуяа* В.Мөнхтуяа



*Зураг 34. Хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангасан байдал*



## ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 07-р сарын 05 өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 13-р хороолол, Юнескогийн гудамж –31, Далай Тауэр, 402 тоотод тоотод байрлах Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Энвайронментал комплайнц” ХХК (цаашид “Компани эсхүл Гүйцэтгэгч” гэх), түүнийг төлөөлж захирал Б.Энхбаяр,

нөгөө талаас Монгол улс, Дархан Уул аймаг, Хонгор сумд байрлах, Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Си Би Зи” ХХК (цаашид “Захиалагч”), түүнийг төлөөлж захирал В.Мөнхтуяа бид нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 зүйлүүдийг үндэслэн дараах нөхцөл бүхий гэрээг харилцан тохиролцож (цаашид “Гэрээ” гэх) байгуулав

### 1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

1.1. Гэрээлэгч нь Захиалагчийн Дархан Уул аймаг Дархан сум Хонгор сум Асгат Уулд байрлах “Си Би Зи” ХХК-д “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” – ийн 10<sup>1</sup> дугаар зүйлд заасны дагуу байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн аудит хийж, улмаар төслийн одоогийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, засаж сайжруулах зүйлс, авах арга хэмжээ, цаашид байнгын сайжруулах боломж бий болгож улмаар Захиалагчид учирч болзошгүй эрсдэл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх болон орон нутгийн иргэд, ажилчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бий болгоход нь тусалж дүгнэлт, зөвлөмж өгөх нь энэхүү аудитын ажлын үндсэн зорилго оршино.

1.2. **Үйлчилгээний тайлбар:** Байгаль орчны төлөвлөгөөт аудит

1.3. **Байршил** Дархан Уул аймаг Хонгор сум “Си Би Зи” ХХК

1.4. **Үйлчилгээ үзүүлэх гэрээний:**

**Эхлэх хугацаа:** 2023 оны 07-р сарын 05-ний өдөр /БОА-н үйлчилгээ гэрээний урьдчилгаа төлбөр төлөгдсөн өдрөөр эхлэнэ./

**Дуусах өдөр:** 2023 оны 07-р сарын 30-ны өдөр хүртэл.

1.5. **Гүйцэтгэх ажлын үндсэн чигэл:**

1.5.1. Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2019.12.25-ний өдрийн А/809 тушаалаар батлагдсан Байгаль орчны аудит хийх журмын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэх,

- 1.5.2. Төслийн талбай дээр биечлэн ажиллаж нөхцөл байдалтай танилцах, төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны бичиг баримтын бүрдэлтэй танилцах, шалгах,
- 1.5.3. БОНБУ-ний тайлангийн хэрэгжилтийн биелэлт буюу нийцлийн үнэлгээ хийх,
- 1.5.4. МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй байгаль орчны хууль, тогтоомж, стандарт, дүрэм журам, бодлогын бичиг баримтын хэрэгжилтийг уурхайн үйл ажиллагаатай уялдуулан хянаж, үл нийцлийг илрүүлэх, цаашид авах сайжруулах арга хэмжээг төлөвлөх, зөвлөмж боловсруулан, дүгнэлт гаргах.
- 1.5.5. Хууль тогтоомжид заасан бусад.

#### **Компанийн үүрэг, хариуцлага**

- 1.6. Компани нь Байгаль орчны аудитын зөвлөх үйлчилгээг сайдын 2019.12.25-ний өдрийн А/809 тушаалаар батлагдсан Байгаль орчны аудит хийх журам, Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журам болон Захиалагчаас тавьсан шаардлагад нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд чанартай хийж гүйцэтгэнэ.
- 1.7. Компани нь захиалагчийн үйл ажиллагаа болон хэрэгжүүлж буй хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахын тулд бичиг баримтын аудит, нотлох баримт цуглуулах болон холбогдох ажилчидтай уулзалт хийнэ.
- 1.8. Компани нь Захиалагчийн төслийн талбайд ажиллаж бичиг баримтаар цуглуулсан мэдээллийг нягтлах ажиглалтын мэдээ цуглуулах ба мөн төслийн үйл ажиллагаатай танилцана.
- 1.9. Компани нь Байгаль орчны аудитын явцад цуглуулсан бичиг баримт, нотолгоо, мэдээлэл дээр үндэслэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг гаргана.
- 1.10. Гүйцэтгэгчийн ажилчид нь Гэрээт ажлыг гүйцэтгэх хангалттай дадлага туршлагатай мэргэжлийн хүмүүс байх ба Гэрээт ажлыг гүйцэтгэх явцдаа Захиалагч болон Гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд хохирлыг бүрэн хариуцна.
- 1.11. Захиалагчийн ажлын байрны онцгой нөхцөл байдлыг дээд зэргээр анхааран ажлын байранд элдэв зөрчил гаргахгүй, Захиалагчийн өдөр тутмын ажил болон түүний гэрээлэгч, гуравдагч этгээдийн ажилд саад учруулахгүйгээр Гэрээт ажлыг гүйцэтгэх үүрэгтэй. Энэ үүргээ зөрчсөнтэй холбогдох хариуцлагыг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.
- 1.12. Гүйцэтгэгч нь ажлын талбайг дүрэм журам, стандартын дагуу зөв зохион байгуулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн

шаардлагыг ханган ажиллах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ зөрчсөнтэй холбогдох хариуцлагыг Гүйцэтгэгч тал хүлээнэ.

### **Захиалагчийн үүрэг, хариуцлага**

- 1.13. Захиалагч нь Байгаль орчны аудит хийх бүхий боломжийг компанид гаргаж өгнө.
- 1.14. Захиалагч нь төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны өөрт байгаа бичиг баримт, нотлох баримтуудыг ажлын байранд бэлэн байлгаж аудитын хөтөлбөрийг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- 1.15. Гэрээт ажлын явцад өөрийн нутаг дэвсгэр, үйлдвэр объект, ажлын байранд чөлөөтэй нэвтрүүлэн, дээж, сорьц авах, хэмжилт хийх, холбогдох бусад мэдээллийг цуглуулах бололцоогоор хангана.
- 1.16. Аюулгүй ажиллагааны нэг бүрийн хамгаалах хувцас, хөдөлмөр хамгааллын хэрэгслийг бүрэн хангана.
- 1.17. Захиалагч нь өөрийн төслийн хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм журмыг танилцуулж, Аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулж, аюулгүй, ажлын бүтээмжтэй ажиллах нөхцлийг хангана.

## **2. ТӨЛБӨР ТООЦОО:**

- 2.1. Байгаль орчны аудитын үйлчилгээний зардал нь аливаа татвар хураамж (НӨАТ тооцогдоогүй болно) багтсан дүнгээр **1 500 000 /Нэг сая таван зуу мянга / төгрөг** болно.
- 2.2. Гэрээний үнэд аудитын үйлчилгээ, холбогдох судалгаа хийх, дүгнэлт гаргах, тайлан боловсруулах, удирдлага, зохион байгуулалт багаж хэрэгсэл ашиглах үнэ, Улаанбаатар хотоос төслийн талбай хүртэлх тээврийн зардал, холбогдох татвар хураамж, Гүйцэтгэгчийн ажиллагсдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, болзошгүй бусад зардал зэрэг Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардагдах бүхий л зардлууд багтсан болно.

## **3. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

- 3.1. Гэрээний үнийг Захиалагч дараах хуваарийн дагуу төлнө. Үүнд:
  - 3.1.1 Талууд гэрээг байгуулан баталгаажуулсан өдрөөс хойш ажлын 3 хоногт гэрээний урьдчилгаа төлбөр болгон гэрээний үнийн **50 хувь буюу 750**

**000 /Долоон зуун тавин мянга/** төгрөгийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн түүний дансанд шилжүүлнэ.

3.1.2 Гүйцэтгэгч тал гэрээгээр тохирсон үүргээ бүрэн биелүүлж, Захиалагчид танилцуулан Гэрээт ажлын үр дүнг хүлээлгэж өгснөөс хойш ажлын 5 хоногт багтаан үлдэгдэл төлбөр буюу гэрээний үнийн **50 хувь буюу 750 000/ Долоон зуун тавин/** төгрөгийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ. Үлдэгдэл төлбөр шилжсэний дараа Экологийн хариуцлагын гэрээг байгуулна.

3.2 Төлбөрийг **Төрийн банк, 104 100 628 173 (MNT)** тоот дансанд шилжүүлнэ.

#### **4. ХАРИУЦЛАГА.**

4.1. Аль нэг тал энэ гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсвэл ийнхүү биелүүлэх боломжгүй гэдэг нь нэгэнт тодорхой болсон, Гэрээт ажлыг дараалан 20 хоног, эсвэл нийт 30 хоног хойшлуулсан, аль нэг тал нь дампуурсан эсвэл бусдад эрхээ шилжүүлсэн тохиолдолд тухайн хохирогч талын санаачилгаар гэрээг цуцална.

4.2. Энэхүү гэрээнд заасан төлбөрийн хугацааг хэтрүүлбэл хоног тутамд гүйцэтгээгүй төлбөрийн 0,5 хувьтай тэнцэх алдангийг төлбөрийн хамт төлөх хариуцлага хүлээнэ.

4.3. Аль нэг талын буруугаас гэрээг цуцалсан тохиолдолд учирсан шууд болон шууд бус аливаа хохирлыг буруутай талаар нөхөн төлүүлнэ.

#### **5. ЭКОЛОГИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ**

5.1. Талууд энэхүү гэрээг байгуулж, Гүйцэтгэгч зөвлөмж, дүгнэлтээ Захиалагчид хүлээлгэн өгсөний дараа “Экологийн хариуцлагын гэрээ” –г холбогдох хууль, дүрэм, журмын дагуу байгуулж ажиллана.

#### **6. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ.**

Ажил гүйцэтгэх явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах, нэмэлт гэрээ байгуулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

#### **7. БУСАД:**

7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад гарсан маргаантай асуудлыг хоёр тал эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол

асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

- 7.2 Талууд энэхүү гэрээг 2% үйлдэж Захиалагч 1 хувь, Компани 1 хувийг хадгалах бөгөөд гэрээний хувиуд хуулийн адил хүчинтэй байна.
- 7.3 Ажил гүйцэтгэгч нь ажил үүрэг гүйцэтгэх хугацаандаа болон гэрээ дуусгавар болсны дараа гэрээнд тусгайлан заасан хугацааны турш олж мэдсэн, танилцсан аливаа мэдээ, мэдээлэл, бичиг баримт бизнесийн үйл ажиллагааны нууцыг задруулахгүй чанд хадгална. Захиалагчийн нууц мэдээ, мэдээлэлд ажил хэрэгтэй холбоотой санхүүгийн, геологийн, хуулийн гэрээтэй холбоотой баримт бичиг, объект, үйл ажиллагааны талаарх мэдээ, зураг, тооцоо зэрэг нь “Нууц мэдээлэлд” хамаарна.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### КОМПАНИ

Захирал Б. ЭНХБАЯР



Утас 99083500

#### ЗАХИАЛАГЧ

Захирал В. МӨНХТУЯА



Утас 99053180

Зураг 35. Байгаль орчны аудит хийж гүйцэтгэх ажлын гэрээ



ХААН БАНК

Огноо/Date: 2023.08.09 12:14:55

### Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000512963530

Системийн огноо/System Date: 2023.08.09 11:57:46

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5086046007	В****Я МӨНХТУЯА	1,500,000.00 MNT	1.00
/ Нэг сая таван зуун мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр Bank Name		
	34	Төрийн банк		
	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name		
	104100628173	ЭНВАЙРОМЕНТАЛ КОМПЛАЙНЦ	1,500,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

Си Би Зи ХХК-с аудитын үнэлгээний төлбөр (байгаль орчин)

Зураг 36. Байгаль орчны аудит хийлгэх ажлын төлбөр төлсөн баримт

# БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

*Байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн аудит*

Аудитын тайлантай танилцаж хүлээн авсан:

Нэр	Албан тушаал	Гарын үсэг

2023 он

0



Хаяг: Оффис 1209, UB Tower Plus,  
13-р хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн  
гудамж, 83/1, 25-р хороо, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот 13374, Монгол улс  
Гар утас: 99083500  
Имэйл: enheecz@gmail.com

Зураг 37. Байгаль орчны аудитын тайлан

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН  
НИЙЦЛИЙН ХӨНДЛӨНГИЙН АУДИТ  
Аудитын тайлан № Е.АН2023-17

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Си Би Зи ХХК-ийн Асгат уул шохойн чулууны уурхайн үйл ажиллагаанд “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” –ийн 10<sup>1</sup> дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчны багц хуулиуд тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, тогтоол, байгаль орчны стандартуудын заалтууд болон үйлчлүүлэгч байгууллагын 2019 онд хийгдсэн БОННУ-ний тайлангийн нийцлийн аудитыг 2023 оны 06-р сарын 25-30 өдрүүдийн хооронд хийж гүйцэтгэв.

Тус төслийн байгаль орчны аудитыг БОННУ болон бусад БО-ны баримт бичгүүдийн хяналт, төслийн талбай дээрх шалгалт, холбогдох ажилтнуудтай хийсэн ярилцлага болон цуглуулсан баримт нотолгооны дээр үндэслэн аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэг үндсэн үйл ажиллагааны дагуу хийв.

Си Би Зи ХХК-ийн Асгат уул шохойн чулууны уурхайн төсөл Байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажилд анхаарал тавьж байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэж байгаа нь сайшаалтай байлаа.

Төслийн үйл ажиллагаанууд нь хууль эрх зүйн хувьд нийт 24 хуулийн 293 зүйл заалтаас хамаарал бүхий 153 зүйл заалтын хэрэгжилтийг шалгахад нийцлийн 150 заалт буюу 98%, үл нийцэл 3 заалт буюу 3%, байлаа.

Аудитын хугацаанд үйлчлүүлэгч байгууллагын холбогдох ажилтнууд дэмжин хамтран ажилласан бөгөөд ямар нэгэн саад тогтор, хөндлөнгөөс нөлөөлөх байдал гараагүй болно.

Гарын үсэг:



Б.Энхбаяр, Ахлах аудитор

Огноо: 2023.07.30

БАТЛАВ. “ЭХЛЭХ ЦЭГ ХАНГАЙ” ХХК-НЫ  
ЗАХИРАЛ Л.ПҮРВЭЭ

ДАРХАН-УУЛ - ИМАГ  
БАТЛАВ. “СИ БИ ЗИ” ХХК  
ЗАХИРАЛ И.ЗИ В.МӨНХТУЯА

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН  
БАТАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2023 оны 06 дугаар сарын 09

№ 2023/77

Дархан-Уул аймаг

Энэхүү Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил гүйцэтгэхтэй холбогдуулж /2076624/ “Си Би Зи” ХХК-ны эзэмшил 4502004946, бүхий нэгж талбарын дугаартай гэрээ (“гэрээ”)-г нэг талаас цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас, 1-р хороолол, 16-р баг 18-р баг 43 тоот, 4274148 тоот регистрийн дугаартай “Эхлэх цэг хангай” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх)-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Ч.Чимгээ бид дараах нөхцөлүүдийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр гэрээг байгуулав.

**Нэг. Ерөнхий заалт**

- 1.1. Энэхүү гэрээ нь “Газрын тухай хууль”-ийн 23, 58 дугаар зүйлийн дагуу захиалагчийн эзэмшилд байгаа эдэлбэр газрын нэгж талбарт газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийж гүйцэтгэх /цаашид “ажил” гэх/-ийг гүйцэтгэгчид даалгаж, гэрээт ажил гүйцэтгэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

**Хоёр. Ажилд тавигдах шаардлага, гүйцэтгэх хугацаа**

- 2.1. Ажилд тавигдах шаардлага:
  - 2.1.1. 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Барилга хот байгуулалтын сайдын 34 дүгээр тушаалаар батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх аргачилсан заавар”-ын 3, 4-р хавсралтад заасны дагуу “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа”-г хийхэд заавал хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.
  - 2.1.2. Ажлын гүйцэтгэл нь үнэн зөв бодитой Монгол улсад мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн байна.
- 2.2. Ажил гүйцэтгэх хугацаа:
  - 2.2.1. Гүйцэтгэгч нь Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайланг 2023 оны 06 дугаар сарын 09 ны өдрөөс 2023 оны 8 дугаар сарын 31 ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.
  - 2.2.2. Газрын төлөв байдал, чанарын улсын, төлөвлөгөөт, захиалгат хянан баталгааны ажил нь 05 дугаар сарын 01-наас 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэл хээрийн судалгаа буюу хөрсний дээж, ургамлын бичиглэл хийнэ гэж журманд заагдсан байдаг бөгөөд бусад хугацаанд тухайн ажил гүйцэтгэхэд шаардлагатай бэлтгэл болон суурь судалгааны ажлуудыг боловсруулна.
  - 2.2.3. Энэхүү гэрээний 2.2.3-т заагдсан бэлтгэл болон суурь судалгааны ажилд дараах ажлууд хамаарна. Үүнд:
    - 2.2.3.1. Тухайн ажлыг гүйцэтгүүлэх ИААНБ-ын улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрөл
    - 2.2.3.2. Үйл ажиллагааны танилцуулга
    - 2.2.3.3. Газрын гэрчилгээ, гэрээний хамт
    - 2.2.3.4. Газрын кадастрын зураг
    - 2.2.3.5. Мэдэгдэх хуудас
    - 2.2.3.6. Өмнө хийгдэж байсан хянан баталгааны тайлан, дүгнэлт
    - 2.2.3.7. БОНБУ-ний тайлан
    - 2.2.3.8. Тухайн орчны байгаль орчин болон газар ашиглалтын судалгаа
    - 2.2.3.9. Нэгж талбарын суурь зураг зэрэг багтана.

**Гурав. Ажлын хөлс төлөх журам**



- 3.1. Захиалгат ажлын хөлсний нийт дүн (“ажлын хөлс”)-г Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх ажлын төлөвлөгөө, зардлын тооцоонд зааснаар тохиролцов. Харин нэгэнт хийсэн буюу хийж эхэлсэн захиалгат ажлыг захиалагчийн хүсэлтээр дахин гүйцэтгэх (өөрчлөх) буюу түүнтэй адилтгах бусад шалтгааны улмаас зарцуулсан нэмэгдэл материалын болон ажиллагааны өртөг зардлыг захиалагч хариуцна.
- 3.2. Ажлын хөлсний нийт дүн
- 3.3. Гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаанд 2.200.000 /НӨАТ тооцсон дүн/ төлбөр 100 хувийг гэрээ хийсэн өдөрт, ХААН банкны: “Эхлэх цэг хангай” ХХК-ний 5046466799 дансанд шилжүүлэх.

#### **Дөрөв. Захиалгат ажлын чанарын талаар**

- 4.1. Захиалгат ажлын чанар нь журмын шаардлагыг хангасан байх ёстой. Хэрэв энэхүү журмын шаардлага нь тухайн ажлын чанарыг зөв, гүйцэт тодорхойлоход хангалттай биш байвал тухайн төрлийн ажлын чанарт тавигддаг стандартын буюу мэргэжлийн үзүүлэлтийн нийтлэг шаардлагад нийцсэн байвал зохино.
- 4.2. Захиалагч нь шаардлагатай гэж үзвэл ажлын үр дүнг хүлээн авахдаа хөндлөнгийн байгууллагын мэргэжлийн шинжээчээр захиалгат ажлын чанарыг шалгуулах эрхтэй.
- 4.3. Гүйцэтгэсэн ажлын чанарт ямар нэгэн дутагдал илэрвэл түүнийг нэн даруй засахыг захиалагч шаардах эрхтэй ба ажил гүйцэтгэгч нь уул шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 4.4. Ажил гүйцэтгэгч нь захиалагчийн шаардлагыг биелүүлээгүй бол нэгэнт гүйцэтгэсэн ажлынхаа гүйцэтгэлийн үнийг төлүүлэхээр нэхэмжлэх эрхээ алдана.
- 4.5. Захиалгат ажлыг хүлээн авах үед энгийн аргаар шалгаад илрүүлэх боломжгүй (далд) дутагдлын тухай гомдлыг захиалагч ажлын гүйцэтгэлийг хүлээн авснаас хойш гурван сарын дотор гаргах эрхтэй. Энэ хугацаа өнгөрснөөс хойш гаргасан гомдлыг авч хэлэлцэхгүй.

#### **Тав. Захиалагчийн эрх, үүрэг**

- 5.1. **Захиалагч нь дараах үүрэгтэй:**
  - 5.1.1. Шаардлагатай баримт, мэдээллээр гүйцэтгэгчийг хангах,
  - 5.1.2. Гүйцэтгэгчийн шаардсан судалгаа, материалыг гарган өгөх,
  - 5.1.3. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тайлан дүгнэлтийг мөрдөж ажиллах.
- 5.2. **Захиалагч нь дараах эрхтэй:**
  - 5.2.1. Ажлын гүйцэтгэх хуваарийн биелэлтэнд хяналт тавих, ажлын явцтай танилцаж санал зөвлөмж өгөх,
  - 5.2.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, зохих ёсоор биелүүлэхийг гүйцэтгэгчээс шаардах,
  - 5.2.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол захиалагчид учирсан хохирлоо нэхэмжлэн авах, гэрээг нэг талын санаачлагаар цуцлах.

#### **Зургаа. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

- 6.1. **Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй:**
  - 6.1.1. Гэрээнд заасан хугацаа, нөхцлөөр, өөрийн хөрөнгө, багаж, техник хэрэгслийг ашиглан чанарын өндөр түвшинд ажлыг хийн гүйцэтгэж, холбогдох тайлан дүгнэлт, төлөвлөгөөг боловсруулан хүлээлгэж өгөх ба холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардагдсан бол эдгээр тайлан, төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар батлуулах эсвэл хянуулсан байх,
  - 6.1.2. Ажлын явц, цаашид авах арга хэмжээний талаар захиалагчид тогтмол мэдэгдэж байх,
  - 6.1.3. Шаардлагатай гэж үзвэл ажлыг шаардлагын хэмжээнд явуулах үүднээс хууль зүй, техник, удирдлага зохион байгуулалтын талаар захиалагчтай харилцан зөвшилцөх,
- 6.2. **Гүйцэтгэгч нь дараах эрхтэй:**
  - 6.2.1. Ажил гүйцэтгэхтэй холбоотой мэдээ, мэдээлэл баримтыг захиалагчаас авах
  - 6.2.2. Гэрээний 3 дугаар зүйлд заасны дагуу захиалагчаас төлбөрөө шаардах,
  - 6.2.3. Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах

6.2.4. Захиалагч тал шаардлагатай бичиг баримтыг бүрэн бүрдүүлж өгөөгүй шалтгаанаар гэрээт ажилын хугацаанаас хойшлох тохиолдолд хариуцлагыг хүлээхгүй болно

#### **Долоо. Захиалагчийн хяналт ба гүйцэтгэлийг хүлээн авах**

- 7.1. Захиалагч хянан баталгааны ажлын гүйцэтгэлийн явц, чанарыг шалгах эрхтэй.
- 7.2. Ажлын гүйцэтгэлийг захиалагчид хүлээлгэж өгөх явц дараах хэсгээс бүрдэнэ:
  - 7.2.1. Хянан баталгааны ажлыг мэргэжлийн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулах,
  - 7.2.2. Төрийн захиргааны төв байгууллагаас гүйцэтгэсэн ажлын дүгнэлтийг баталгаажуулах,
  - 7.2.3. Газрын төлөв байдал, хянан баталгааны тайлан болон дүгнэлтийг захиалагчид хүлээлгэн өгөх.
- 7.3. Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд буюу ажлыг зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй нь ажлын гүйцэтгэлийн явцад илэрхий болсон буюу ажлын дутагдлыг тогтоосон хугацаанд арилгаагүй бол захиалгат ажлыг ажил гүйцэтгэгчийн зардлаар өөр ажил гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх буюу захиалагч гэрээг дангаар цуцалж, урдчилан төлсөн хөлсийг ажил гүйцэтгэгчээс гаргуулан, учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.
- 7.4. Захиалагч ажлын гүйцэтгэлийг албан ёсоор хүлээн авахаас өмнө түүний чанар, байдалтай танилцах үед ямарваа дутагдал илэрвэл түүнийг арилгуулсны дараа хүлээн авна. Хэрэв илэрсэн дутагдал нь гүйцэтгэсэн ажлын үр дүнг цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй гэж захиалагч үзвэл ажлын үнийг зохих хэмжээгээр багасган төлж ажлын гүйцэтгэлийг хүлээн авах эрхтэй.
- 7.5. Ажил гүйцэтгэгч нь энэ гэрээний 1.4-д заасан хугацаа дуусахаас өмнө захиалгат ажлын төгсгөл буюу үр дүнг /Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын тайлан, нэгж талбарын паспорт/-ыг шалгуулж мөн хугацаа дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан захиалагчид актаар хүлээлгэн өгнө.
- 7.6. Актанд ажлын чанар, хугацааны мөрдөлт, засварлалт (хэрэв байсан бол) зэрэг ажил гүйцэтгэсэн явц, нөхцлийг тэмдэглэж талуудын төлөөлөгчид гарын үсэг зурна.

#### **Найм. Хариуцлага**

- 8.1. Ажил гүйцэтгэгч энэ гэрээнд заасан 2.2.1-д заасан хугацаанд захиалгат ажлыг гүйцэтгэж, ажлын үр дүнг захиалагчид бүрэн хүлээлгэж өгөөгүй бол, эсхүл захиалагчийн тогтоосон хугацаанд чанарын дутагдлыг арилгаагүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутамд энэхүү гэрээний 3.2-т заасан үнийн дүнгийн 0,3%-тай тэнцэх хэмжээний алданги төлнө.
- 8.2. Тайланг баталгаажуулах явцад буюу төрийн байгууллагын үйл ажиллагаанаас үүдэн хугацаа хойшлох тохиолдолд ажил гүйцэтгэгч захиалагчид гэрээний хугацаа дуусахаас 3 хоногийн өмнө мэдэгдэх бөгөөд ингэсэн тохиолдолд 8.1 заалтыг мөрдөхгүй.
- 8.3. Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс үүдэлтэйгээр жич: /гал, үер, шуурга, аянга цахилгаан, нийгмийг цочроосон өвчин/ тайлант хугацаанд хүлээлгэн өгч амижаагүй тохиолдолд гэрээг дахин сунгах
- 8.4. Ажил гүйцэтгэгчийн зүгээс энэ гэрээний аль нэг нөхцөлийг зөрчсөн ямар нэгэн дутагдал гаргаагүй буюу гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлсэн байхад захиалагч энэ гэрээнд заасан хугацаанд захиалгат ажлын үнийг төлөхгүй саатуулбал ийнхүү хугацаа хожимдуулсан хоног тутам төлөөгүй үнийн дүнгийн 0,3%-тай тэнцэх хэмжээний алданги төлнө.
- 8.5. Захиалагч нь ажил гүйцэтгэгчийг ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллээр хангах бөгөөд түүнээс болж алдсан хугацаанд алданги тооцохгүй.
- 8.6. Энэ гэрээг цуцалсан тохиолдолд гэрээгээр өгч, авсан зүйлээ харилцан буцаах үүргээ аль нэг тал нь нөгөө талын тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол энэхүү гэрээний 8.1, 8.3-д заасан хэмжээгээр алданги төлнө.

#### **Ес. Бусад нөхцөл**

- 9.1. Энэ гэрээ нь талуудын хооронд энд дурдсан асуудлаар тогтсон хэлцлийн бүхий л нөхцөл, ойлголтуудыг тодорхойлон илэрхийлж байгаа бөгөөд энэ гэрээ хүчин төгөлдөр болсноор үүнээс өмнө талуудын хооронд энэхүү гэрээний зүйлийн талаар хийсэн бүх

хэлцэл, хэлэлцээ, амлалт, ойлголтууд (хэрэв тийм зүйл байсан бол)-ыг энэ гэрээ өөртөө багтаасан болно.

9.2. Энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг болон энэхүү гэрээнд заасан ашиг сонирхлоо аль ч тал нь нөгөө талын урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

9.3. Энэ гэрээнд заагаагүй аливаа асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


9.4. Энэ гэрээ нь талуудын төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж дээрх журмаар гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр гэж тооцогдоно.

9.5. Энэхүү гэрээг талууд харилцан тохиролцож 2 хувь үйлдэв.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

<p><b>ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ</b></p> <p>“ЭХЛЭХ ЦЭГ ХАНГАЙ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ</p> <hr/> <p><i>Ч.Чимгээ</i></p> <p><b>Ч.ЧИМГЭЭ</b> Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг 1 хороолол, 18-43 тоот хаягт Утас: 88229095 Имэйл: Ehleh.hangai@gmail.com</p>	<p><b>ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ</b></p> <p>ДАРХАН-УУЛ АЙМАГ ЗАХИРАЛ.....В.МӨНХТУЯА</p> <hr/> <p><i>В.Мөнхтуяа</i></p> <p><b>СИ БИ ЗИ</b> ХХК ТТ02600...2076624</p> <p>Хаяг: Дархан-Уул, Хонгор сум 1-р баг Утас: 99053180, 99053485</p>
--	--

Зураг 39. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил гүйцэтгэх гэрээ



## ХААН БАНК

Огноо/Date: 2023.07.27 16:44:37

### Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 24974354

Системийн огноо/System Date: 2023.07.07 15:06:07

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5086046007	В****Я МӨНХТУЯА	1,500,000.00 MNT	1.00
/ Нэг сая таван зуун мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр Bank Name		
	05	Хаан банк		
	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5046466799	ЭХЛЭХ ЦЭГ ХАНГАЙ	1,500,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

Зураг 40. Хянан баталгааны ажлын төлбөр төлсөн баримт



## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2023 оны 07 дугаар сарын 10

№ 23/1

Улаанбаатар хот

Нэг талаас: регистрийн 6573061 дугаартай “Жондоо Гарден” ХХК,  
(цаашид “Гүйцэтгэгч” гэх)

Нөгөө талаас: Си Би Зи ХХК

(цаашид “Захиалагч” гэх)

нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ доорх нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### 1. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ

1.1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэгч нь дор дурдсан гол нөхцөлөөр гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, нүхэн жорлонгийн стандарт, захиалагчийн захиалга, шаардлагад нийцүүлэн гүйцэтгэж, ажлыг хүлээлгэн өгөх, захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, ажлын хөлсийг гэрээнд заасны дагуу төлөх үндсэн үүргийг тус тус хүлээнэ. Үүнд:

а	Ажлын нэр	Эко нойл - хаалгатай
б	Ажлыг эхлүүлэх огноо	2023.07.31
в	Ажлыг гүйцэтгэх хугацаа, эсхүл гүйцэтгэж дуусгах огноо	2023.08.02
г	Гэрээний үнийн дүн (НӨАТ-орсон)	3,465,000 төг
	Тээвэр	-
д	Төлбөр нөхцөл	100%-тай тэнцэх 3,465,000 төгрөг
	Дансны дугаар	Жондоо Гарден ХХК, Хас банк 5004155035
е	Баталгаат хугацаа	1 (нэг) жил (бүхээг, тоноглол) хамаарна. нүхний ажил болон бохирын кольцо хамаарахгүй!!!
ё	Ажлын зураг байгаа эсэх	байгаа
ж	Ажлын талбай, байршил	
з	Материалд тавигдах шаардлага	Хүний эрүүл мэндэд харшлахгүй, стандарт, чанартай материал байна.
и	Үүргийн гүйцэтгэлийг хангах арга	Хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг хугацаа хэтрүүлсэн буруутай тал нь нөгөө талдаа төлнө.
й	Захиалагчийн төлөөлөгчийн нэр,	В.Мөнхтуяа
к	Регистрийн дугаар	
	Утасны дугаар	99053180

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас: 1/4

	Цахим шуудангийн хаяг	
л	Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн нэр, Албан тушаал	Р.Алтансүх – ҮАХ захирал
	Утас	80802399: 99189603
	Цахим шуудангийн хаяг	jondoozuslan@gmail.com
м	Хавсралт	Ажлын жагсаалт

## 2. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

### 2.1. Гүйцэтгэгч нь:

- 2.1.1. Захиалгат ажлыг батлагдсан загвар, материалын дагуу хугацаанд нь чанартай гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгнө
- 2.1.2. Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн туслан гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулах, түүний үүргийг захиалагчийн өмнө бүрэн хариуцна.
- 2.1.3. Ажлын гүйцэтгэлд гарсан эвдрэл гэмтэл нь Захиалагчийн болон гуравдагч этгээдийн санаатай болон болгоомжгүй үйлдэл, эс үйлдлийн улмаас учирсан нь тогтоогдсон тохиолдолд хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх ба Гүйцэтгэгч хариуцлага хүлээхгүй
- 2.1.4. Захиалагч гүйцэтгэсэн ажлыг хүндэтгэх шалтгаангүйгээр хүлээн авахгүй бол ажлыг гүйцэтгэсэнд тооцож эцсийн тооцоо хийх, учирсан хохирлыг нэхэмжлэх эрхтэй.
- 2.1.5. Захиалагч техникийн шаардлага болон зураг төслийг шинэчлэх тохиолдолд Гүйцэтгэгч уг ажлыг харилцан тохиролцсоны дагуу төлбөртэй гүйцэтгэнэ.
- 2.1.6. Ажлын гүйцэтгэл саатах, тасалдах эсвэл нэмэлт зардал гарч болохоор байдал үүссэнийг мэдсэн бол Захиалагчид нэн даруй мэдэгдэнэ. Гүйцэтгэгч нь тэдгээр сөрөг үр дагаврыг арилгах бололцоотой бүх арга хэмжээг авна.
- 2.1.7. Захиалагчийн ажлын талбайд ажил гүйцэтгэх явцад мэдэгдээгүй далд байдлаас үүсэх хариуцлагыг захиалагч дангаар хариуцна. Үүнд: Цахилгааны болон шугамын кабель утас, дулаан бохирын шугам гэх мэт

### 2.2. Захиалагч нь:

- 2.2.1. Ажлын санхүүжилтыг гэрээний дагуу үе шат бүрээр тасралтгүй хийх үүрэгтэй.
- 2.2.2. Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд Гүйцэтгэгчийн ажилтныг ажлын талбайд орж гарах, ажил хийхэд шаардлагатай нөхцөлөөр хангана. (ажлын талбай байршил заах, цахилгаан үүсвэр, ус, машин техник орох гарах, ажиллах зэрэг нөхцлөөр хангах)
- 2.2.3. Захиалагчийн зүгээс ажлын гүйцэтгэлтэй холбоотой нэмэлтээр зураг төсөл, техникийн шаардлагыг өөрчилсөн тохиолдолд нэн даруй Гүйцэтгэгчид мэдэгдэх бөгөөд нэмэлт өөрчлөлтөөс үүдэн гарах нэмэлт ажлын хөлсийг Захиалагч хариуцна.
- 2.2.4. Гүйцэтгэгчийн дотоод ажилд хутгалдан оролцохгүйгээр ажлын явц, түүний чанар, үр дүнд хяналт тавина.

## 3. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 3.1. Захиалагчийн төлбөрийн санхүүжилтээс болон газрын маргаан, бусад нөхцлөөс шалтгаалан ажил тасалдсан бол суд зогссон, хойшилсон хугацааны зардал, хохирлыг захиалагч тал хариуцна.

## 4. ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨР

- 4.1. Үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн Гүйцэтгэгч нь энэ гэрээнд заасан нөхцөл хугацааны дагуу ажлын хөлсийг авах эрхтэй.
- 4.2. Төлбөрийг гэрээний гол нөхцөлд заасан нөхцлийг үндэслэн шилжүүлгээр хийнэ





Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас: 2/4

**5. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

5.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, үер, бороо, салхи, шуурга, гал түймэр, халдварт өвчин, байгалийн бусад хүчин зүйлс болон төрийн шийдвэр оролцоо гэх мэт) -ийн нөхцөл байдлын улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас (алданги, торгууль) чөлөөлөгдөх үндэслэл болно.

**Гэрээ байгуулсан:**

<p><b>Гүйцэтгэгчийг төлөөлж:</b></p> <p>“Жондоо Гарден” ХХК:</p> <p>Захирал </p>  <p>Хаяг: БГД, 2 дугаар хороо, 2 дугаар хороолол, Энхтайвны өргөн чөлөө, 63 байр</p> <p>Утас: 80802399 9918 9603</p>	<p><b>Захиалагчийг төлөөлж:</b></p> <p>“Си Би Зи” ХХК:</p>   <p>Хаяг: Дархан-Уул аймаг, дархан сум, 15-р дүүрэг, үйлдвэрийн район, Силикат үйлдвэрийн байр.</p> <p>Утас: 99053180 Факс:</p>
--	---

Зураг 41. Эко “00” суурилуулах ажил гүйцэтгэх гэрээ

**Шилжүүлгийн баримт/Transaction receipt**

noreply@khanbank.com <noreply@khanbank.com> Mon, Jul 31, 2023 at 11:55 AM  
To: SILIKAT1966@gmail.com

Огноо/Date: 2023.07.31 11:55:04

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information  
Журналын/Journal No: 000507134982

Системийн огноо/System Date: 2023.07.31 11:55:04

Дт/From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5086105463	СИЛИКАТ	2,892,000.00 MNT	1.00
/ Хоёр сая найман зуун ерэн хоёр мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 32	Банкны нэр/Bank Name ХАСБАНК - ХАСБАНК		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 5004155035	Нэр/Name ЖОНДОО ГАРДЕН ХХК	2,892,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:  
ЕВ-Эко Жорлон Дархан 99053180

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тэмдэг/Stamp:

Зураг 42. Эко “00” суурилуулах ажлын төлбөр төлсөн баримт

**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН  
СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан БОАЖЯ-ны цахим системд цаг хугацаанд нь илгээсэн болно.

## ДҮГНЭЛТ

Манай компани нь 2023 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилт ихтэй үед зам усалгааг тогтмол хийж байсан.
- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших эвдрэлд өртсөн 0.4 га талбайд /нийт 8 хэсэг газар/ нөхөн сэргээлт хийсэн.
- ✓ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 576 ш хайлаас мод тарьсан.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан.
- ✓ Эко “00” шинээр суурилуулж ашиглалтад оруулсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
- ✓ Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэсэн
- ✓ Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг хийлгэж дүгнэлт гаргуулсан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаар, хөрс, усны шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн.

2023 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хийгдэх ёстой ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн болно.